



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2015 оны 4 сарын 22 өдөр

Дугаар 120

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7 дахь заалт, Үндэсний аулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4.6 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн аудитын байгууллагуудад мөрдөх “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам”, “Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлийн үйл ажиллагааг зохицуулах журам”, “Компьютер техник, тоног төхөөрөмж болон дотоод сүлжээ, цахим шуудан ашиглалтын журам”-ыг тус тус хавсралтаар баталсугай.

4. Байгууллагын үйл ажиллагаандаа энэхүү журмыг мөрдлөг болгон ажиллахыг Үндэсний аудитын газар болон аймаг, нийслэлийн аудитын газрын тэргүүлэх аудитууд болон нийт ажилчдад үүрэг болгосугай.

5. Дээрх журмыг хэрэгжүүлэхэд төрийн аудитын байгууллагуудад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, хяналт тавьж, хамтарч ажиллахыг Үндэсний аудитын газрын Тамгын газар /Л.Дулмаа/-д, тушаалын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Ерөнхий менежер /Э.Отгон/-д тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБОО, ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Төрийн аудитын байгууллагууд /цаашид “ТАБ” гэх/ нь мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлийн аливаа үйл ажиллагааг шинээр хийж хэрэгжүүлэх, нэвтрүүлэх болон цаашдын байнгын үйл ажиллагааг ханган ажиллахад энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.2. Энэхүү журмын зорилт нь дээрхи 1.1-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд Мэргэжлийн эрх бүхий мэдээлэл технологийн баг /цаашид “МЭБМТБ”/ нь чиг үүргийн дагуу тогтоон зохицуулахад оршино.

1.3. “Мэдээллийн технологи” гэж аливаа электрон хэлбэрээр илэрхийлэгдсэн өгөгдөл, мэдээ, мэдээллийг бүтээх, хадгалах, боловсруулах, дамжуулах, илэрхийлэх зорилго бүхий техник ба програм хангамжийн тогтолцоог хэлнэ.

1.4. МЭБМТБ нь төрийн аудитын мэдээлэл, харилцаа холбоо, технологийн асуудал эрхэлсэн Үндэсний аудитын газрын Тамгын газрын албан хаагчдын бүрэлдэхүүн байна.

1.5. МЭБМТБ энэ журмын хэрэгжүүлэх ажлыг арга зүйн удирдлагаар хангах үүрэгтэй.

Хоёр. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлийн ажил үйлчилгээг шинээр хийх, шинэчлэн сайжруулах

2.1. Мэдээлэл, харилцаа холбоо технологийн чиглэлийн ажил үйлчилгээг шинээр хийх, шинэчлэн сайжруулахад ТАБ-ын үүрэг:

2.1.1. Газрын үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэх, сайжруулах санал санаачлага гаргаж төсөл хөтөлбөрүүдийг боловсруулан МЭБМТБ-аас мэргэжил арга зүйн дэмжлэг авч хамтран ажиллах;

2.1.2. Шаардлагатай зардлыг жил бүр байгууллагынхаа төсөвт суулгуулж байх;

2.1.3. Шинээр хийж хэрэгжүүлж буй ажлуудыг чанаржуулах, хяналтыг сайжруулах, байнга гардаг зардлыг бууруулах, нэгдсэн бодлогод уялдуулах үүднээс техникийн болон програмын даалгавар, шаардлагыг мэргэжлийн эрх бүхий МЭБМТБ-тай хамтарч боловсруулах;

2.1.4. Тодорхой ажлуудыг МЭБМТБ-тай зөвшилцсөний үндсэн дээр гүйцэтгүүлэх;

2.1.5. Хувийн хэвшлийн байгууллага аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлж буй ажлын явц, гүйцэтгэлд мэргэжил арга зүйн хяналтыг МЭБМТБ-аар гүйцэтгүүлэх;

2.1.6. Ажлыг бүрэн хэрэгжүүлсний дараа шинээр хэрэгжүүлсэн ажлынхаа зохиогчийн эрхийг эзэмшиж, баримт бичиг, эх кодын нэг хувийг МЭБМТБ-ын гаргасан шаардлагад нийцүүлэн хүлээлэн авах;

2.1.7. Ажлынхаа шинэчлэлт, өөрчлөлтийг тухай бүрт нь мэргэжлийн эрх бүхий МЭБМТБ-т өгч баримтжуулж хадгалуулна.

2.2. Мэдээлэл, харилцаа холбоо технологийн чиглэлийн ажил үйлчилгээ шинээр хийх, шинэчлэн сайжруулахад МЭБМТБ-ын үүрэг:

2.2.1. Дараа жилийн шинээр хийж хэрэгжүүлэх ажлынхаа санал, төслийг санхүүгийн үйл ажиллагаа эрхлэн явуулж буй албан хаагчдад өгөх, удирдлагуудад танилцуулга хийх.

2.2.2. Санаачилсан төсөл, хөтөлбөрүүдийг судалж нэгдсэн бодлоготой уялдуулан, шаардлагатай төслүүдийг хэрэгжүүлэх, гадаад, дотоод санхүүжилт олоход мэргэжлийн зүгээс хамтарч ажиллах;

2.2.3. ТАБ-дыг мэдээллийн технологийн дэвшил, шинэ технологи, тоног төхөөрөмжийн талаарх шинэлэг мэдээллээр хангах;

2.2.4. Төрийн аудитын системийн хэмжээнд мэдээллийн технологийг ашиглах арга замыг өргөжүүлэн сайжруулах, шинээр нэвтрүүлэх, хэрэгжүүлэх ажлыг санаачлан зохион байгуулах;

2.2.5. Гэрээ байгуулж тодорхой төлбөртэйгээр програм, техник хангамжуудыг шинээр хийх болон засвар үйлчилгээ, сервер, сүлжээний ажлыг гүйцэтгэх;

2.2.6. ТАБ-н хэмжээнд хийгдэж буй ажлуудын техник болон програмын даалгаврыг боловсруулах, хүлээлцэх ажилд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж хамтарч оролцох;

2.2.7. ТАБ-дад шинээр хийж хэрэгжүүлж буй ажлуудыг чанаржуулах, хяналтыг сайжруулах байнга гардаг зардлыг бууруулах, нэгдсэн бодлогод уялдуулах үүднээс ажил гүйцэтгэх гэрээнд санал өгөх, хүлээлцэх актын загварыг гаргаж хэрэгжүүлэх;

2.2.8. Тогтоосон хүрээнд хяналт хийж, дүгнэлт гарган удирдлагуудад тогтмол танилцуулж, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах;

2.2.9. Шинээр нэвтрүүлж, хэрэгжүүлж байгаа програм, техник хангамжийн баримт бичиг, эх кодын нэг хувийг хадгалах;

Гурав. Хөгжүүлэх, байнгын үйл ажиллагааг хангаж ажиллах

3.1. Шинээр болон шинэчлэн сайжруулсан тоног төхөөрөмж, програм хангамжийг өмчдөө бүртгэж хөгжүүлэлт, байнгын үйл ажиллагаа, мэдээллийн шинэчлэлтийг бүрэн хариуцаж ажиллана.

3.2. ТАБ-дын сүлжээний чиглэлээр хийгдсэн ажлуудын дотоод сүлжээ нь төрийн аудитын өмч байх бөгөөд гадаад сүлжээ нь төрийн болон аж ахуйн нэгжийн өмч байна.

3.3. ҮАГ нь вэб, мэйл, сервер програмуудыг байрлуулах нэгдсэн сервертэй байх ба тэдгээрийн байнгын үйл ажиллагааг МЭБМТБ хариуцан ажиллана.

3.4. Мэдээлэл, харилцаа холбоо технологийн чиглэлийн ажил үйлчилгээг хөгжүүлэх, байнгын үйл ажиллагааг ханган ажиллахад Төрийн аудитын байгууллагуудын үүрэг:

3.4.1. Байгууллага дээр ажиллаж байгаа техник, програм хангамжуудыг мэдээллийн технологийн хөгжилтэй зэрэгцүүлэн шинэчлэх, хөгжүүлэх ажлыг зохион байгуулах;

3.4.2. Програм, техник хангамж, сервер, сүлжээний ажлуудыг шинээр хийлгэх, хөгжүүлэх болон цаашдын байнгын үйл ажиллагааг засвар үйлчилгээг МЭБМТБ хариуцан ажиллах;

3.4.3. МЭБМТБ-тай зөвшилцсөний үндсэн дээр хувийн хэвшлийн байгууллага аж ахуйн нэгжээр тодорхой гэрээтэйгээр хөгжүүлэлт, байнгын үйл ажиллагааг хариуцуулан ажиллах;

3.4.4. Вэб суурьтай програм хангамж болон сервер програмуудыг нэгдсэн серверт байрлуулах;

3.4.5. Төрийн аудитын нэгдсэн портал <http://www.audit.mn> болон дотоод вэб сайтуудад нэвтрэх адим эрх бүхий албан хаагч нь өөрийн газрын мэдээ, мэдээлэл болон өөрчлөлт шинэчлэлтийг тухай бүрд нь шуурхай оруулж байх;

3.5. Мэдээлэл, харилцаа холбоо технологийн чиглэлийн ажил үйлчилгээг хөгжүүлэх, байнгын үйл ажиллагааг ханган ажиллахад МЭБМТБ-ын үүрэг:

3.5.1. Мэдээллийн технологийн дэд бүтцийн өөрчлөлт шинэчлэлт, байнгын найдвартай үйл ажиллагааг ханган ажиллах;

3.5.2. Төрийн аудитын вэб хуудас, програм хангамжийн шинэчлэлтийг мэдээллийн технологийн хөгжилтэй зэрэгцүүлэн хөгжүүлж байх;

3.5.3. Хийгдсэн ажлын баталгаат хугацаа дууссан үед техник, програм хангамж нь гэмтсэн, засварлах байнгын үйл ажиллагааг хангах шаардлага гарсан үед МЭБМТБ нь баримт бичиг, эх кодын дагуу холбогдох аж, ахуйн нэгжээр үйлчилгээг үзүүлэх;

3.5.4. Компьютер тоног төхөөрөмжийн шаардлага хангах дотоод өгөгдөл стандартыг гаргаж жил бүр шинэчилж харьяа газруудад мэдээлэх;

3.5.5. Ашиглалтын шаардлага хангахгүй болсон компьютер, тоног төхөөрөмж болон гадаад дотоод сүлжээнд стандарт шаардлагын дагуу мэргэжлийн дүгнэлт гаргах;

3.5.6. Мэдээллийн технологи, харилцаа холбооны чиглэлийн сургалт арга хэмжээг тогтмол зохион байгуулах;

3.5.7. Төрийн аудитын нэгдсэн сервер дээр засвар хийх, аливаа техникийн саатал, гэмтлийг арилгах зорилгоор серверийн үйл ажиллагааг түр зогсооход харьяа газруудад урьдчилан мэдэгдэнэ.

3.5.8. Төрийн аудитын нэгдсэн портал <http://www.audit.mn> болон дотоод вэб сайтуудын байнгын найдвартай ажиллагааг хариуцан ажиллах;

3.6. Сервер, сүлжээ, холбоо, дагалдах тоног төхөөрөмжүүдийн байнгын найдвартай үйл ажиллагааг хангаж ажиллахад орон нутгийн мэдээлэл, технологийн асуудал хариуцсан албан хаагчдын үүрэг:

3.6.1. Орон нутгийн мэдээлэл, технологийн асуудал хариуцсан албан хаагч нь тоног төхөөрөмжүүдийн байнгын найдвартай үйл ажиллагааг хангаж, хариуцаж ажиллах;

3.6.2. Суурилуулсан тоног төхөөрөмжүүд нь Төрийн аудитын өмч бөгөөд байрлаж буй газрууд нь байрандаа засвар шинэчлэл хийх тохиолдолд заавал МЭБМТБ-т урьдчилан мэдэгдэх;

3.6.3. Тухайн газрын эзэмшил хэсэгт байрлаж буй тоног төхөөрөмжүүдийн байрыг өөрчлөх, задлах, засварлахыг хориглох;

3.6.4. 3.7.1-д заасан этгээд нь сүлжээ, холбооны эвдрэл гэмтэл гарсан үед МЭБМТБ-аас гаргаж өгсөн анхан шатны оношлогооны гарын авлагын дагуу засварлах оношлох үүрэгтэй;

3.6.5. Гарын авлагын дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд МЭБМТБ-д хандана;

3.6.6. ТАБ-ын тоног төхөөрөмжүүдийн байнгын үйл ажиллагааг хангаж ажиллахад шаардлагатай журмыг МЭБМТБ нь санаачлан боловсруулж хэрэгжүүлж ажиллана.

3.7. Албан хаагч ажлаас чөлөөлөгдөх, халагдах үед хэрэгцээт файл, програмыг хүлээлцэхгүй байх мөн вирус, гадны халдлагаас хамгаалах үүднээс газрууд дотоод үйл ажиллагаандаа дараах зүйлсийг заавал мөрдөж ажиллана:

3.7.1. АНАГ нь мэдээллийн технологи, хэвлэл мэдээллийн асуудлыг хавсран хариуцсан албан хаагчтай байна;

3.7.2. ТАБ-ын албан хаагчид нь дотоод сүлжээнд ажиллах тусгай серверт бичиг баримт, хэрэгцээт мэдээлэл, файл, програмуудыг өөрсдийн эрхээр хандан орж хуулж, баяжуулах байх.

3.7.3. Дээрхи сервер компьютерт буй мэдээллийг МЭБМТБ нь тусгай тоног төхөөрөмжид улирал бүр нөөцөлж хадгална.

3.7.4. Албан хаагч ажлаас чөлөөлөгдөх, халагдах зэрэг ажил хүлээлцэх тохиолдолд тухайн ажлын байранд холбогдолтой мэдээлэл, файл, тусгай програмыг заавал хүлээлцэнэ.

3.7.5. Ажил хүлээлцэх хуудасны загварыг МЭБМТБ боловсруулж газруудад хүргүүлнэ.

Дөрөв. Мэдээллийн сангийн бүтэц, үйл ажиллагаа

4.1. Мэдээлэл, харилцаа холбоо технологийн чиглэлийн бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох төсөл хөтөлбөрүүдийн хоорондын уялдаа холбоог сайжруулах, нэгдсэн бодлогоор хангах, зорилгоор мэдээллийн санг дараахь бүтэцтэйгээр зохион байгуулна:

Тоног төхөөрөмжүүдийн сан

Програм хангамжуудын сан

Сүлжээний мэдээллийн сан

Төсөл хөтөлбөрүүдийн сан

4.2. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг МЭБМТБ эрхэлнэ.

4.3. ТАБ-ууд нь дараа жилийн шинээр хийж хэрэгжүүлэх ажлынхаа санал, төслийг сангийн үйл ажиллагааг эрхлэн явуулж буй МЭБМТБ-д жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан ирүүлнэ.

4.4. ТАБ-ууд нь компьютер тоног төхөөрөмж, програм хангамжид хувийн хэрэг хөтөлнө.

4.6. Техник хангамж, компьютер тоног төхөөрөмжийн хувийн хэрэг нь зориулалт, хүчин чадал, үйлдвэрлэсэн он, өөрчлөлт шинэчлэлт, засвар үйлчилгээ, бүтээгдэхүүний үнэ, марк, сериал, хариуцсан албан хаагч гэсэн мэдээллийг агуулна.

4.7. Програм хангамжийн хувийн хэрэгт зориулалт, бичигдсэн програмчлалын хэл, хэмжээ, ажиллах систем, бүтээгдсэн он, өөрчлөлт шинэчлэлт, гүйцэтгэсэн байгууллага, бүтээгдэхүүний үнэ гэсэн мэдээллийг агуулна.

4.8. Нэг тоног төхөөрөмж, програм хангамжид зөвхөн нэг хувийн хэрэг хөтөлнө.

4.9. Хувийн хэрэг хөтлөх загвар, зааврыг МЭБМТБ тогтооно.

Тав. Хариуцлага

7.1. ТАБ нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлсэн програм, техник хангамжийн ажил үйлчилгээний баримт бичиг, эх кодын нэг хувийг МЭБМТБ хүлээлгэн өгөөгүйгээс гарах аливаа үр дагаварыг тухайн газар бүрэн хариуцна.

7.2. Мэдээллийн аюулгүй байдал, нууцыг тухайн газар хариуцна.

7.3. МЭБМТБ нь ТАБ-н мэдээллийн технологийн чиглэлийн дотоод ажилд мэргэжлийн хяналт тавихаас өөрөөр хөндлөнгөөс оролцох, төсөл хөтөлбөрүүдийг заавал өөрийн саналаар гүйцэтгүүлэх, шаардахыг хориглоно.

7.4. Энэхүү журмыг зөрчсөнөөс байгууллагад учирсан хохирлыг шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтан хариуцна.

7.5. Энэхүү журамд тусгагдаагүй бусад харилцааг холбогдох эрх зүйн акт, гэрээний дагуу зохицуулна.